



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 95

Номгон

Үндсэн хөрөнгө актлах, суулгац модыг эргэлтийн хөрөнгөд шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “а”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 40 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах журам”-ын 1.3, 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сум дундын Ойн ангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 10 нэрийн 44 644 500 төгрөгийг өртөг бүхий модыг нэгдүгээр хавсралтаар баталж, акталж данснаас хассугай.

2. Тус байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 22 нэрийн 51 415 500 төгрөгийн өртөг бүхий хоёрдугаар хавсралтад заагдсан суулгац модыг эргэлтийн хөрөнгөд шилжүүлж бүртгэсүгэй.

3. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Идэрмөнх/-д дор дурдсан ажлыг зохион байгуулахыг даалгасугай.


3.1. Актлагдсан, шилжүүлсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

3.2 Хөрөнгийг комисс томилон хүлээн авч устгал хийх зардлыг тухайн байгууллагаас гаргуулах;

3.3. Тогтоолын хэрэгжилтийг 2019 оны 10 дугаар сард багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд ирүүлэх.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

1190150